

## НИЙГМИЙН ФИЛОСОФИЙН САЛБАР ДАХЬ Ж.С.МИЛЛИЙН ҮЗЛИЙН ОНЦЛОГ

Б.Мөнхжавхлан - МУИС, НШУС, Философиин тэнхим, магистр

**Түлхүүр үгс:** "хүний дэвшил" гэдэг Ж.С.Миллийн ойлголт. Нийгмийн дэвшлийн тухай Ж.С.Миллийн "эрх чөлөө" гэдэг ойлголт. Дедукцийг Ж.С.Милль ангилсан онцлог. Төлөөллийн засаглалын талаархи Ж.С.Миллийн шинжилгээний арга зүй.

Английн философич Жон Стюарт Милль (1806-1873) нийгмийн философи, ялангуяа түүхийн философи, ёс зүйн философи, улс төрийн философи зэрэг түүний салбаруудад агуулга, арга зүйн ач холбогдол бүхий олон чухал санааг дэвшүүлсэн юм. Ингэхдээ тэрээр Жереми Бентам, эцэг Жеймс Милль зэрэг философичдын адил улс төрийн онолын судалгаандаа дедуктив аргыг тодорхой байдлаар ашиглажээ. Үүнд: энэ хоёр философич хүний мөн чанарыг судлахад психологийн аксиомуудаас урьд улс төрийн үйл ажиллагааны практик дүрмүүд болон улс төрийн онолын зарчмууд чухал гэж үзэж байсан байна.

Гэтэл бас арга зүйн энэ дедуктив хандлагад английн улс төрийн философич Томас Макклай (1800-1859) шүүмжлэлтэй хандаж, хүний мөн чанарын тухай онол бол хүмүүсийн үйлдэл суурилахаас илүү тэдний таашалын төлөөх хүсэлд тулгуурлаж тайлбарлагдах ёстой гэсэн байна. Тэгээд тэрээр: анхны априори зарчмуудаас түрүүнд практикт хэрэглэгдэх байдлыг судалгаанд авч үзэх нь зохистой байдаг. Бид улс төрийн талаархи мэдлэгийг түүхийг судалж, ажиглаж байж олж авдаг. Түүхэн үйл явдлуудыг тэмдэглэж, ажиглаж үр дүнг нь харгалзах нь хамгийн зөв гэж Т.Макклай үзсэн юм.

Тэгвэл Ж.С.Миллийн хувьд хэлэхэд тэрээр эцгийнхээ болон английн бусад зарим философичийн баримталсан дедуктив аргыг онцлохдоо Т.Макклайн утилитарист дээрх санааг ихэд дэмжсэн байдаг. Түүний үзлээс харахад дедуктивизм, индуктивизм хоёр Ж.С.Миллийн философи судалгаанд нягт холбогдсон байдаг.

Гэхдээ Ж.С.Миллийн философи судалгаанд индуктив арга зонхилох ач холбогдолтой. Тэрээр индуктив логикийг боловсруулснаараа өндөр үнэлэгддэг бөгөөд энэ логикийн асуудлыг боловсруулсан түүний нэг чухал бүтээл нь 1843 онд нийтлэгдсэн "Силлогист ба индуктив логикийн тогтолцоо" гэдэг бүтээл нь юм(1). Улмаар тэрээр энэхүү аргаа дедуктив аргатай харгалзуулж үзсэн дараах хэлбэрүүдийг илрүүлж, тэдгээр тус бүрийн онцлогийг дурдсан байна. Үүнд(2):

1. Индуктив буюу химиин арга. Энэ бол жич ажиглагдагч нөхцөл байдлын харьцуулан авч үзсэний үндсэн дээр шалтгаант хуулийг нээдэг арга мөн. Энэ аргыг түүхийг судлахад ашиглаж болох бөгөөд харин улс төрийн шинжлэх ухаанд ашиглахад тохиромжгүй гэж Ж.С.Милль тайлбарласан байдаг.

2. Шууд дедуктив буюу геометрийн арга. Энэ бол анхдагч ерөнхий зарчмуудаас бага ерөнхий хуулиуд руу шилждэг силлогистик арга мөн. Энэ аргыг ашиглаш шалтгааныг тогтооход ажиглагдагч хүчин зүйлсийн нөлөөг онцлон авч үзэх шаардлагахарах албагүй байдаг. Иймээс уг арга математикт тохиромжтой бөгөөд харин механик болон улс төрд ашиглагдах шаардлагагүй гэж Ж.С.Милль үзсэн байна.

3. Тодорхой дедуктив буюу физикийн арга. Энэ бол дан ганц шалтгаант хуулийг иш үндэс болгож биш, бас үр дагаварт нөлөөлж буй бусад бүх шалтгааныг болон хуулийг хамт авч үзэн харгалзаж үр дагаврын хуулиудыг гаргаж авдаг арга мөн. Энэ аргыг химийн шинжлэх ухаанд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд харин нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэхэд тохиромжтой гэж Ж.С.Милль бичсэн байdag.

Ж.С.Миллийн явуулсан арга зүйн шинжилгээ нь тэрээр нийгмийн янз бүрийн үзэгдэл, үйл явдлыг дедуктив зарчмын үүднээс авч үзэж буй тохиолдолд индуктив үндэслэгээг гарцаагүй харгалзах ёстой гэдэг логик, арга зүйн зарчимд тулгуурлажээ гэсэн дүгнэлтийг хийх бололцоог бидэнд олгож байна. Өөрөөр хэлбэл нийгмийн судалгаанд хэрэв ганц дедуктив аргыг үндэс болговол улс төрийн, түүхийн зэрэг нийгмийн янз бурийн үзэгдэл, үйл явдлын гагцхүү тогтворт шинжтэй байдгийг онцлоход хүрэх бөгөөд үүнээс Ж.С.Милль зайлсхийжээ. Түүний хувьд тэдгээр үзэгдэл үйл явдлыг өөрчлөгдөмтгий, тогтвортой байдаггүй талтайг судалгаандаа гарцаагүй харгалзсан байdag. Чухам энэ нь тэрээр (өмнө дурдсанчлан) дедуктивизм, индуктивизм хоёрыг судалгаандаа уялдуулан ашиглахад хүргэсэн бололтой.

Энэ санаагаа зөвтгөж нэг зүйл дурдахад Ж.С.Милль нийгмийн шинжлэх ухааныг хоёр салбарт хуван авч үзсэн байна(3). Эдгэрийн нэг нь бүх нөхцөлд суурь хэвээр байдаг шинжлэх ухаанууд (жишээ нь: улс төрийн эдийн засгийн ухаан) мөн. Нөгөөх нь хүчин зүйл, нөхцөл хэрхэн өөрчлөгддөг вэ гэдгийг авч үздэг шинжлэх ухаанууд (жишээ нь: түүхийн философи) юм. Эдгээр нь улс төрийг судлах явцад хоёул хэрэгтэй нөхцөл мөн гэж тэрбээр үзээд нэн түрүүнд түүхийн философиийн салбар дахь судалгааныхаа үр дүнг ийм үзэлдээ нэг чухал үндэслэгээ болгожээ. Үүнд: түүний тайлбараар хүн төрөлхтөн буудуулэг (Barbarism) ниймээс иргэншилд дэвшин шилжиж ирсэн. Гэхдээ энэхүү урагш дэвших хөдөлгөөн нь өөр өөр газар, өөр өөр нийгэмд явагдаж байсан бөгөөд энэ бол хүний дэвшил (прогресс) явагдаж байна гэсэн үг. Хүн ямагт дэвшлийн дагуу явж, дараагийн шатанд очих хэрэгтэй. Иймд түүхийн философи бол нийгмийн дэвшлийн тухай философи, улс төрийн шинжлэх ухааны суурь, шинжлэх ухааны хэмжүүр (dimension) болж байдаг ажээ.

Тэгээд Ж.С.Милль: одоогийн нийгэм дэх засгийн газар зорилгодоо хүрэхийн тулд юу хийх нь чухал вэ гэдгийг мэдэхээс илүүтэй хүн төрөлхтөн цаашид иргэншлийн өндөр шатанд хүрэхийн тулд яах вэ гэдгийг мэдэх нь чухал юм гэж үзсэн байdag. Тийнхүү хүн төрөлхтөн тухайн өндөр хөгжсөн нийгмээс бүр илүү боловсронгуй нийгэмд хэрхэн очих тухай боддог байх хэрэгтэй.

Ж.С.Милль нийгмийн дэвшлийн тухай түүхийн философи үзлээ боловсруулахдаа хүн төрөлхтний оюун ухааны дэвшлийн тухай О.Контын үзлийг арга зүйн үндсээ болгосон байdag. Түүнийхээр (О.Контынхоор) хүн төрөлхтний оюун ухаан урагшлан дэвших явцдаа теологи, метафизик, позитив гэсэн гурван үндсэн шатыг дамжсан. Гэхдээ энэ үзлийг Ж.С.Милль жирийн хуулбарлаагүй. Учир нь, О.Контын хувьд позитив шат бол сэтгэхүйд буюу оюун ухаанд холбогддог. Харин Ж.С.Миллийн хувьд позитив шат бол зөвхөн оюун ухаанд биш, харин нийт нийгмийн дэвшилд холбогддог.

Гэхдээ нийгмийн дэвшлийн үндэс бол угтаа үзэл санаа мөн гэдэг арга зүйн зарчмыг Ж.С.Милль баримталж, үүгээрээ О.Контын арга зүйтэй ямар нэг байдлаар нийцдэг. Гэвч энд ч гэсэн эл хоёр философийн үзэлд тодорхой ялгаа байdag. Үүнд О.Конт нь

сэтгэхүйн талыг, өөрөөр хэлбэл танин мэдэхүйн талыг онцолж байсан бол Ж.С.Милль нь ёс зүйн талыг, өргөн утгаар хэлбэл үнэлэмжийн талыг онцлох замаар дэвшлийн тухай тус тус өгүүлсэн ажээ.

Тийнхүү нийгмийн дэвшлийн тухай Ж.С.Миллийн түүхийн философи үзэл нь ёс суртахууны философи(ёс зүйн) үзэлтэй уялддаг байна. Хүн төрөлхтний нийгэм урагшлан дэвших нь санаа, тэр тусмаа ёс суртахуунлаг, оюунлаг удирдагчдаас хамаарна. Дээд бодгалиуд буюу оюунлаг, ёс суртахуунлаг хүмүүс нь эрх чөлөөний дор төрж өндийдөг. Иймд эрх чөлөө бол дэвшлийн зайлшгүй нөхцөл мөн.

Ийнхүү Ж.С.Миллийн үзлээс дүгнэлт хийвэл дэвшил бол шинэ санаанаас хамаардаг, гэхдээ тухайн шинэ санаа нь хуучин хүлээн зөвшөөрөгдөж байсан санаанаас улбаатай байдаг. Гэхдээ түүний хувьд шинэ санаа, шинэ ёс суртахуун бол хуучныхаа жирийн үргэлжлэл төдий биш байдаг бөгөөд учир нь, шинэ санаа бол хэд хэдэн хувилбар бүхий байж, тэдгээрээс хийсэн сонголт эрх чөлөөний зарчимд нийцэж байлаа ч гэсэн хамгийн гол нь шинэ нийгмийн тогтворт байдлын үндэс болж байх ёстай.

Ж.С.Милль ёс суртахууны сонголтыг утилитариизм(утилитарианизм)-д үндэслэх ёстой гэж үзжээ. Түүний хувьд утилитариизм бол “...зан суртахууны үндэслэгээ нь ашиг тус буюу аль болох их жаргалтай байх зарчим мөн хэмээн зөвшөөрч, үйлдлийг жаргалд холбогдох харьцааны үүднээс үнэлдэг, энд жаргал руу хөтөлдөг үйлдлийг сайн, харин жаргалгүй рүү хөтөлдөг үйлдлийг муу гэдэг сургаал мөн. Энэ сургаал «жаргал» гэдэг үгийн дор таашаал ба зовлон амсахгүй байхыг, «каргалгүй» гэдэг үгийн дор зовлон, таашаалгүй байх хоёрыг ойлгодог”(4). Тэгээд тэрээр: хүний нийгэм бол илүү дээд иргэншилд очих, дээд зэргийн таашаалыг эдлэх хүслийг агуулж байдаг. Дээд зэргийн таашаалыг хайх нь угтаа нийгмийг улам боловсронгуй болгоход чиглэгдэж байдаг. Дээд зэргийн таашаал нь нийгмийн эрх чөлөөг шаардаж байдаг бөгөөд чөлөөт нийгэм л иргэншиж чадна гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Улмаар Ж.С.Милль энэхүү утилитарианист зарчмаа дэвшлийн тухай үзэлтэйгээ уялдуулах замаар улс төрийн философи үзлээ боловсруулсан байдаг. Үүнд түүний тайлбараар хүмүүс хамтаар амьдарч зорилгоо биелүүлэх явцдаа өөр, шинэ таашаал руу тэмүүлж байдаг. Тийм тэмүүлэл хэрэгжихэд засгийн газар онцгой роль бүхий байх ёстой. Учир нь үйлдэл бол зөвхөн бодгальд биш, харин олон хүнд, улмаар нийт нийгмийн гишүүдэд жаргал өгч байх ёстой байдаг. Тиймээс засгийн газар нь зөвхөн иргэдийн хүсдэг таашаалыг өдөөгөөд зогсохгүй харин дээд таашаалыг хайхад, өөрөөр хэлбэл нийт иргэдээ боловсруулахад чухал үйл ажиллагаа явуулж, үүндээ хариуцлага хүлээдэг байх ёстой. Тийнхүү ёс суртахууны боловсрол бол зөвхөн бодгаль хүмүүсийн биш, бас засгийн газрын үйл хэрэг мөн юм. Сайн нийгмийн хариуцлага нь хүмүүст ёс суртахууны боловсрол олгож, хүнийг зөвхөн таашаал хайгч амьтан төдий бус, харин дэвшилд хүрэгч болоход туслах ёстой.

Тийнхүү Ж.С.Миллийн хувьд бодгаль хүн бол сайтар зохион байгуулагдсан нийгэм дэх сайтар боловсорсон хүн болж дэвших ёстой. Тэгж боловсорсон хүн бол бусаддаа үлгэржишээ, загвар болдог зөвхөн бодгаль хүн төдий биш, харин өөрийнхөө хөгжлөөр бусад хүн дэвших нөхцлийг бүрдүүлдэг тийм төлөвшөн хүн байх аж. Хүмүүсийн дэвшил хангагдсанаар тэд идэвх санаачлагатай, төрийн хуулийг сохроор дагах байдлаас

ангижирсан байж чаддаг гэсэн санааг Ж.С.Милль утилитарианист улс төрийн онолдоо илэрхийлсэн байдаг.

Хариуцлагатай засгийн газар, шинжлэх ухааны мэдлэг хоёр бол орчин үеийн иргэншлийн гол шинж мөн гэж Ж.С. Милль үзжээ. Ийм үзлийнхээ үүднээс Баруун Европ, АНУ хоёр иргэншлийн дээд шатанд хүрсэн хэмээн бүрэн итгэлтэй байжээ. Ингэхдээ тэрээр “нийгмийн урагшлах хөдөлгөөн ардчиллаас, илүү сайн ардчилалд, илүү тэгш байдалд чиглэдэг” гэсэн францын философич А.Токвиллийн (1805-1859) үзлийг дэмжсэн. Тэгш байдал, шударга ёс хоёр бол эрх чөлөө, оюун ухаан зэргээс илүүтэй байж цаашдын дэвшилд хүргэнэ гэж Ж.С.Милль бичсэн байдаг.

Гэвч эндээс: Ж.С.Милль тэгш байдал, шударга ёс хоёр бол эрх чөлөө, оюун ухааны хүчин зүйлээс хамаардаггүй гэж үзсэн мэт дүгнэлт хийх үндэсгүй байдаг. Харин ч түүний тайлбараар эрх чөлөө, оюун ухааны дэвшил хоёр бол тэгш байдал, шударга ёс тогтоох гарцаагүй нөхцөл мөн. Ер нь эрх чөлөө бол иргэншсэн нийгмийн дэвшлийн гол нөхцөл болдог гэсэн санаа Ж.С.Миллийн бүтээлүүдэд илэрдэг юм. Тэрээр арга зүйн ийм хандлагынхаа үүднээс төрийн засаглалын асуудлыг шинжилсэн байна. Үүнд иргэншилд чиглэсэн дэвшил нь бодгалийн эрх чөлөөг шаардаж, нөгөөтэйгүүр ямарваа хориг, хязгаарлалтаас бодгалийг чөлөөлөх явдал байдаг. Тийм учраас Ж.С.Миллийн хувьд нийгмийн дэвшлийг хангах засгийн газрын үүрэг хариуцлагаас илүүтэйгээр бодгаль хүний эрх чөлөөг дээдлэх чухал байдаг. Иргэншсэн нийгэмд бодгаль хүн өөрийн сонирхлын дагуу чөлөөтэй, өөрийгөө хөгжүүлэх үйл явцын маш чухал нөхцөл бол боловсрол мөн. Гэхдээ боловсрол бол бодгаль хүний хөгжлийн төдийгүй, нийт нийгмийн дэвшлийн нөхцөл юм. Тийм учраас боловсрол бол засгийн газрын бас нэг чухал үүрэг хариуцлага болж байх ёстой.

Эрх чөлөөний гол зарчим бол засгийн газар, бодгаль хүн аль аль нь үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх, үйлдэл хийх боломж мөн боловч энэхүү зарчмыг нийгмийн аюулгүй байдлын төлөө хязгаарлах шаардлага бас бий гэж Ж.С.Милль үзсэн байна. Гэхдээ ийм хязгаарлалт, хяналт нь бодгаль хүмүүс бие биедээ хөнөөл, хохирол учруулахаас хамгаалж буй хэрэг/түүний хувьд бодгаль хүмүүс бол дурын хэнбугтай нар биш, харин нийтийн өмнө тодорхой хариуцлага хүлээсэн боловсролтой иргэд мөн/. Гэхдээ засгийн газрын хяналт, хязгаарлалт ихэсвэл эрх чөлөөнд харш гэж Ж.С.Милль үзсэн юм.

\* \* \*

Ж.С.Миллийн утилитарианизм, бодгаль хүний эрх чөлөөг дээдэлсэн үзэл нь орчин үеийн нийгмийн философи сэтгэлгээнд чухал нөлөө үзүүлж иржээ.

Харин энд нэг зүйлийг бид судалгаа ба сурталчилгаандаа гарцаагүй харгалздаг байх ёстой гэж үзэж байна. Тэр нь юу вэ гэвэл: шинжлэх ухаан бол тодорхой үзэгдлүүдийн дараалалтай ба төсөөтэйн үл өөрчлөгдөх харилцаануудыг судлан нээхэд чиглэдэг; ”О.Конт., Курс позитивной философии.-Антология мировой философии, Т. 3, с 554” хэмээн үзсэн позитивизмыг үндэслэгч О.Контын үзлийг Ж.С.Милль баримталсан юм. Ж.С.Милль бас философи бол “түүхэн тодорхой үедээ тохирсон сэтгэхүйн арга мөн” гэж О.Конт томъёолсныг баримталсан байдаг. Тиймээс позитивист философи бол үзэгдлийн түвшний мэдлэгт холбогддог арга байж таардаг. Тэгээд позитивистууд өөрсдийн янз бүрийн философи үндэслэлийг, түүний дотор нийгмийн философиийн салбар дахь

үндэслэлүүдээ үзэгдлүүдийн түвшинд хүчинтэйгээр ойлгож, улмаар чухам ийм арга зүйнхээ үүднээс улс төрийн философи, түүхийн философи, эдийн засгийн философи зэрэг нийгмийн философиийн(өөрсдийн боловсруулсан) салбараа “шинжлэх ухаан” гэж нэрлэж явжээ хэмээн дүгнэж болохоор байдаг. Гэвч энэ бол позитивизмыг, түүний дотор энэ философи дахь нийгмийн онолуудыг шинжлэх ухаан гэж бид дүгнэж байгаа хэрэг биш ээ. Үүнтэй холбогдуулан английйн философич Ф.Коплстон(1907-1994) бичихдээ: позитивизм, түүний дотор неопозитивизм өөрийгөө шинжлэх ухаанч хэмээн зарласан тэр үеэсээ шинжлэх ухаан биш, харин философи болж хувирдаг гэсэн байдгийг энд дурдахад тохиromжтой байна. (См. об этом: Фредерик Коплстон От Фихте до Ницше. М.,2004. Глава. 24). Тийнхүү “нийгмийн шинжлэх ухаан” гэж Ж.С.Миллийн нэрлэж буй мэдлэг бол угтаа нийгмийн философи байдаг.

#### Иш татсан бүтээлүүд

1. Миний хувьд энэ бүтээлтэй танилцсан ном: Антология мировой философии. В четырех томах. Том 3. М.,1971 с, 594-605
2. Ж.С.Миллийн философи аргын онцлогийг шинжилсний үр дүн болж буй нэг бүтээлийн нэр дурдахад: Henry M.Magid. History of Political Philosophy Third Edition. Leo Strauss, Joseph Cropsey USA 1987, p.784-801
3. Д.С.Милль Утилитарианизм. Перевод с английского А.Н.Неведомского. СПб., 1866-1869 Антология мировой философии. В четырех томах. Том ,3 с. 605